

“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД  
2021-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ  
(2025 оны 12 сарын байдлаар )

2025  
аймаг

Орхон

№	Арга хэмжээ	Төсөв /сая.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь
				Он	Түвшин		
<b>Зорилт 2.2.</b> Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.							
1	2.2.1. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдэл, хөгжлийн бэрхшээл үүсгэж байгаа шалтгааныг тодорхойлж, хувь хүний онцлогт тохируулан урьдчилан сэргийлэх, оношлох тогтолцоог санхүүжилтийн аргатай нь уялдуулан бүрдүүлж, үйл ажиллагааг хэвшүүлнэ.	ОНТ	Орон нутгийн төсөвт тусгасан мөнгөн дүн	2023	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр	<p>2025 оны эхний 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 728,121 үзлэг хийгдсэнээс 260,844 нь урьдчилан сэргийлэх үзлэг бөгөөд нийт үзлэгийн 35.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд зохион байгуулагдсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт Орхон аймгаас 71,542 иргэн хамрагдаж, хамрагдалт 67.7 хувьтай байгаа нь 21 аймгаас хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Гэсэн хэдий ч Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2025.09.19-ний өдрийн 05/2192 тоот, Эрүүл мэндийн сайдын 2025.09.17-ны өдрийн 1а/4450 дугаар албан бичгийн дагуу “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг”-ийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс зогсоох шийдвэр гарсан.</p> <p>Аймгийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн 167 байгууллагын 5,615 ажилтан, албан хаагчдыг лавлагаа шатлалын эмнэлгүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах лавлагаа шатлалын эмнэлгийн тоо 2025 онд 3-аас 5 болж нэмэгдсэн байна.</p> <p>Засаг даргын “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд эрэгтэйчүүдийн эрт илрүүлгийн хамрагдалтыг</p>

							<p>нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс 15.0 сая төгрөг шийдвэрлэж, 2025 оны 4, 10 дугаар саруудад ээлжит цэрэг татлагын үеийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог 12 чиглэлээр зохион байгуулан 499 залуучуудыг хамруулж, давхардсан тоогоор 817 өвчлөл илрүүлэн, 129 залуучуудыг эрүүл мэндийн заалтаар цэргийн албанаас чөлөөлсөн. Мөн хүчний байгууллагуудын 847 эрэгтэй ажилтныг хамруулсан урьдчилан сэргийлэх үзлэгээр 1189 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн.</p> <p>2025 онд Эрүүл мэндийн магадлалын зөвлөл 40 удаа хуралдаж, 2987 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэсэн бөгөөд шинээр 384 иргэн бүртгэгдсэн. Үүнээс төрөлхийн бэрхшээл 11.3%, өвчнөөс шалтгаалсан бэрхшээл 55.6%, осол гэмтлээс шалтгаалсан бэрхшээл 33.1%-ийг тус тус эзэлж байна.</p> <p>Мөн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд “Шүд, гар угаалтын аварга шалгаруулах тэмцээн–2025”-ийг анх удаа зохион байгуулж, 5.37 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэв. Орхон аймгийн Эрүүл мэндийн газар нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай хамтран цагаан тоосны бүсэд амьдарч буй 1500 иргэнд амны хөндий, биеийн эрүүл мэндийг дэмжих сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, уг үйл ажиллагааг 13.3 сая төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн.</p>
2	2.2.2. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакциныг хүн бүрд		Үйл ажиллагааны тайлан Хэрэгжилтийн хувь	2023	90,7%	92%	<p><u>Тайлант хугацаанд халдварт өвчний 684 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 2,81 промиллоор их байна. Нийт халдварт өвчний 47.6% амьсгалын зам, 25,8% БЗДХ, 3% гэдэсний, 26.6% бусад халдварт өвчин байна. Дархлаажуулалтын хамралт 99.8% байна. Эрүүл мэндийн сайдын 4, Засаг даргын 2 албан даалгаврын хэрэгжилтийг 90.8-93.5% хангаж ажилласан. Томуу, томуу тест өвчний үеийн бэлэн</u></p>

	<p>хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.</p>					<p>байдал, хариу арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн 4 удаагийн хурлаар 9 асуудал хэлэлцэж, шийдвэрийн хэрэгжилт 95,6% хангагдсан байна. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний хүрээнд Засаг даргын 2024 оны А/586 дугаар захирамжаар байгуулагдсан ажлыг хэсгээс салбар дундын уялдаа холбоог ханган ажиллаж, тулгамдсан асуудал, цаг үеийн нөхцөл байдлын мэдээллийг Аймгийн Онцгой Комисст танилцуулан тухай бүр шийдвэрлүүлж ажилласан. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ, бэлэн байдал, хариу арга хэмжээ, тушаал шийдвэрийн хэрэгжилтийн чиглэлээр Эрүүл мэндийн байгууллагуудад 3 удаа, Хүүхдийн байгууллагуудад 1 удаа дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж өгч ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 92,9% байна. Арга хэмжээний хэрэгжилтийг хангах эрүүл мэндийн газрын даргын тушаал 10, төлөвлөгөө 7, удирдамж 15 батлуулан хэрэгжилтийг 95,7% ханган ажилласан. Эрүүл мэндийн байгууллагуудад тус бүр 5 удаа, боловсролын байгууллагуудад 3 удаа дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж өгч ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 94,2% байна. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 1,5% нэмэгдэж, зорилтот түвшинд хүрсэн байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөрлөг 3, аян 4, сургалт 256 удаа зохион байгуулж, 1600 гаруй хүн хамруулсан. Хэвлэл мэдээллээр 17 удаа мэдээлэл өгч, цахимаар 42 мэдээлэл түгээж, 65000 хүнд хүргэсэн. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 61 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилт 86,1% буюу өмнөх оны мөн үеэс 5,9% нэмэгдсэн байна.</p>
--	--	--	--	--	--	---

3	2.2.4. Аймаг, дүүргийн түвшинд хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулна.		Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулагдсан байх	2023	НЭМТ байгуулагдсан	НЭМТ үйл ажиллагаа тогтмолжсон байх	Аймгийн Засаг даргын захирамжаар 2023 оны А/84 дүгээр захирамжаар Эрүүл мэндийн газрын бүтцэд Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулж, 7 эмч, эмнэлгийн мэргэжилтний орон тоотойгоор аймгийн хүн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна. Тус төв нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үндсэн нэгж болох Хоол шим тэжээлийн кабинет, чийрэгжүүлэлт, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх кабинет, 2 сургалтын танхим, хэвлэл мэдээллийн студи, дархлаажуулалтын хүйтэн хэлхээ зэргийг ажиллуулж байна. Тус хугацаанд Нийгмийн эрүүл мэндийн төвийн 1 мэргэжилтэн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн магистрын хөтөлбөрт хамрагдан суралцаж байна.
4	2.2.5. Иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагддаг болгож хэвшүүлнэ.	ОНТ	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	2023	33.8	50.2	<p>Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх үзлэгт хүн амыг бүрэн хамруулах чиглэлээр ажлын хэсгийн 12 удаагийн хурал, 10 удаагийн дэмжлэгт хяналт, 4 идэвхжүүлэх аян зохион байгуулж, салбар дундын оролцоог ханган ажилласнаар төлөвлөгөөний хэрэгжилт 94.6 хувьтай байна. Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудад нийт 664,606 үзлэг хийгдсэнээс 239,019 нь урьдчилан сэргийлэх үзлэг бөгөөд нийт үзлэгийн 36.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1 хувиар өссөн байна.</p> <p>Аймгийн хэмжээнд пренатологич 2 эмчтэй болж, ургийн үзлэгийг тогтмолжуулан 1357 жирэмсэн эхэд үзлэг хийж, 928 тохиолдолд өвчний учир, 429 эхийг идэвхтэй хяналтад бүртгэв. Жирэмсний эрт үеийн нийлмэл илрүүлэгт 141 эх хамрагдсанаас эрсдэлтэй 20 тохиолдлоос 13-д NIPT, 5-д ургийн усны шинжилгээ хийж, эрхтэн тогтолцооны гажигтай 2 жирэмслэлтийг эрт шийдвэрлэсэн. Ургийн бүтцийн ЭХО-д 270 гаруй эмэгтэй хамрагдаж, олон урагтай 18, дээд шатлалд 7 эхийг илгээсэн. RH-сөрөг 2, ургийн гажигтай 11 тохиолдлыг оношлон 3-р шатлалд илгээсэн.</p>

							<p>1610 нярайг нярайн тандалт, скрининг шинжилгээнд 100% хамруулж, үүнээс түнхний үений эхо 1605 (99.6%), сонсголын скрининг 1111, нүдний улаан рефлекс 1605, бодисын солилцооны 5 төрлийн эмгэг илрүүлэх шинжилгээнд 1180 нярайг хамруулсан. Пульсоксиметрийн скринингийг нэвтрүүлж 165 нярайд зүрхний эмгэг илрээгүй, бодисын солилцооны скринингээр 1 нярайг хяналтад авсан.</p> <p>Сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх үзлэгт 22 сургуулийн 2576 суралцагчаас 2554 (99.1%) хамрагдаж, 1773 (68.8%) тохиолдолд өвчлөлийн сэжиг илэрснээс 720 (28.1%) хүүхдийг эмчлэн эрүүлжүүлсэн. Шүдний илрүүлэгт хамрагдсан хүүхдийн 81.8% нь цооролтой, нүдний илрүүлгээр 20.5% нь нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатай, зүрхний илрүүлгээр 27 хүүхдэд зүрхний эмгэг илэрч хяналтад авсан байна.</p> <p>Ажлын байран дахь эрт илрүүлэгт 192 байгууллагын 15,319 ажилтан, БОЭТ-ийн Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт-сэргийлэлтийн төвд 5083 иргэн хамрагдаж, 147 шинэ хавдар илэрч хяналтад орсон. 2025 оны 9 дүгээр сард Хойд бүсийн ХСҮТ-ийн салбар нээгдсэнээр хавдрын эрт илрүүлгийн чадавхи нэмэгдэж, тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 296 шинэ хорт хавдрын тохиолдол бүртгэгдсэн байна.</p>
5	2.2.6.Төрийн болон аж ахуйн нэгж байгууллага бүр ажилтан, албан хаагчдаа эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, жил бүр урьдчилан сэргийлэх цогц үзлэг, шинжилгээнд хамруулдаг соёлыг хэвшүүлнэ.	ОНТ	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хувь	2023	100%	100%	<p>Эрүүл мэндийн салбарын ажилтан албан хаагч нар 100% эрүүл мэндийн даатгалд хамрагдсан. Мөн салбарын нийт ажиллагсдын 1639 буюу 78% нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан.</p> <p>Урьдчилан сэргийлэх үзлэгийн дүнгээр нэмэлт амбулаторийн оношилгоо, эмчилгээ шаардлагатай 30 ажилтан, стационарт онош тодруулах, хэвтэн эмчлүүлэх шаардлагатай 12 ажилтан илэрсэн</p>

							<p>бөгөөд амбулаторийн түвшинд 30 ажилтан онош тодруулж, өдрийн эмчилгээ хийлгэсэн, 9 ажилтныг хэвтүүлэн эмчилсэн байна.</p> <p>Цацраг идэвхт тоног төхөөрөмжтэй харьцаж ажилладаг дүрс оношилгооны тасгийн 15 ажилтанд зориулан урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах зорилгоор хөтөлбөрийн хүрээнд 1.725.000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, “Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл мэндийн төв”-д хамруулсан.</p>
6	2.2.8.Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааны салбар хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ.		Сургалт сурталчилгаанд хамрагдсан хүний хувь	2023	46,6%	48%	<p>Тайлант хугацаанд төрийн болон төрийн бус 48 байгууллагатай хамтран нөлөөллийн 5 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж, нийт 7387 иргэнийг хамруулсан байна. Үүнд, цагаан тоосны бүсэд амьдарч буй иргэдэд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох 8 удаагийн өдөрлөгөөр сэтгэл зүйн зөвлөгөөний өртөө ажиллуулж, сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгон зөвлөгөө өгч, 566 хүүхэд, 944 насанд хүрэгч буюу нийт 1510 иргэн хамрагдсан.</p> <p>Мөн 12 байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд АНУ-ын Эмори их сургуулийн “Танин мэдэхүйд суурилсан энэрэнгүй сэтгэлийг хөгжүүлэх бясалгал” сургалтыг 2 удаа, “Оксфорд майндфүлнэсс – санамсрын бясалгал” сургалтыг 6 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 3520 иргэнийг хамруулсан.</p> <p>Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Бүх хайраа гэр бүлдээ” нэртэй өдөрлөг зохион байгуулж, эрүүл мэндийн боловсрол олгон, 497 иргэнийг хамруулсан. Малчдын дунд зонхилон тохиолдож буй халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл идэвхтэй амьдралын зөв дадлыг</p>

							<p>төлөвшүүлэх, стресс, сэтгэл гутралаас урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөрлөг зохион байгуулж, 60 гаруй иргэн биечлэн хамрагдсан бөгөөд цахимаар 30 төрлийн мэдээлэл түгээж, 9200 гаруй хүнд хүрсэн байна.</p> <p>Түүнчлэн Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв болон бусад төрийн, төрийн бус байгууллагуудтай хамтран Сэтгэцийн эрүүл мэндийн Дэлхийн өдрийг тохиолдуулан “Гамшгийн үеийн сэтгэцийн эрүүл мэнд” өдөрлөгийг зохион байгуулж, 2 удаагийн давтамжтай 5 төрлийн сэтгэл зүйн сургалт явуулсан. Уг өдөрлөгт сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлдэг 11 байгууллагын 11 өртөө ажиллаж, иргэдэд мэдээлэл, зөвлөгөө, үйлчилгээ үзүүлснээр 1800 иргэн хамрагдсан байна.</p>
7	2.2.9.Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэрэглээг хязгаарлах, архи, тамхи, эм, чихэрлэг ундааны онцгой албан татварын тодорхой хувийг эрүүл мэндийг дэмжих санд төвлөрүүлэх, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах үйл ажиллагааг санхүүжүүлнэ		Хэрэгжсэн төслийн тоо	2023	1	1	<p>Тайлант хугацаанд Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл байхгүй.</p> <p>Бүх төрлийн донтолтыг бууруулах чиглэлээр Орхон аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нийгмийн хөгжлийн хорооны 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 02/12 дугаартай албан бичиг, Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/292 дугаар захирамж, удирдамжийн дагуу архины хэрэглээний эмгэгтэй хүн, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд болон бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Сэтгэц-нийгмийн сэргээн засах төв”, “аддиктологийн төв”-ийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, улмаар орон нутагт бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх төв байгуулах, донтох эмгэгийн тусламжийн үйлчилгээ үзүүлэх, энэ төрлийн ажлыг эрчимжүүлэх хүрээнд салбар дундын уялдаа холбоог сайжруулах, хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор</p>

							холбогдох байгууллагуудын 10 хүний бүрэлдэхүүнтэй туршлага судалсан. Мөн орон нутагт нутагшуулах зорилгоор санал оруулан ажиллаж байна.
8	2.2.10.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.	ОНТ 130,0	Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн хангалтын хувь	2023	91,2%	92%	<p>Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 тоот тушаал, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/418 дугаар, 2025 оны “Эрүүл мэндийн салбарын 2025–2026 оны өвөлжилтийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай” А/375 дугаар тушаал, Эрүүл мэндийн газрын даргаар батлагдсан Орхон аймгийн эрүүл мэндийн салбарын 2025–2026 оны өвөлжилтийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө болон холбогдох бусад эрх зүйн баримт бичгүүдийг үндэслэн өвөлжилт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн тусламж, үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө, явуулын эмнэлгийн тусламж үйлчилгээний бүрэлдэхүүний хуваарийг баталж, бэлэн байдлыг ханган ажиллаж байна.</p> <p>Аймгийн Ажиллагааны шуурхай штабын бүрэлдэхүүнд оролцон, батлагдсан хариуцлагатай жижүүрийн хуваарийн дагуу Эрүүл мэндийн газрын албан хаагчид үүрэг гүйцэтгэж, бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Эрүүл мэндийн газрын гамшгийн нөөцөд 1 нэр төрлийн 4.81 сая төгрөгийн эм, 5 төрлийн 4.6 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багажийн яаралтай тусламжийн багц, 3 нэр төрлийн 27.0 сая</p>

						<p>төгрөгийн хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөц бүрдүүлсэн байна. Эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн үеийн нөөцийн хангалт дунджаар 91.6–92.5 хувьтай байгаа нь зорилтот түвшинд хүрсэн үзүүлэлт юм.</p> <p>Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээ авах чадавх 95–96 хувьтай, өмнөх оны түвшинг хадгалан ажиллаж байна.</p> <p>Мөн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүлээн авах болон хэвтэн эмчлүүлэх тасгуудад төлөвлөгөөт бус хяналт хийж, өгсөн зөвлөмжийн дагуу халдвартын болон яаралтай тусламжийн тасгуудад дутагдалтай байсан 6 нэр төрлийн тоног төхөөрөмжийг хангах зорилгоор орон нутгийн төсвөөс 130.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлж, тусламж үйлчилгээний бэлэн байдал, хүртээмжийг сайжруулсан.</p>	
9	2.2.11.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.		Шинээр нэвтрүүлсэн тусламж үйлчилгээ	2023	11	12	<p>Тайлант хугацаанд гэр хорооллын иргэдэд эмийн сангийн тусламж, үйлчилгээг ойртуулах зорилгоор 2 дугаар зэрэглэлийн 2 эмийн сан шинээр нээж, 2 эмийн санг гэр хорооллын байршилд шилжүүлэн байршуулсан. Мөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд хүүхдийн (1), чих хамар хоолойн (1), уламжлалт анагаах ухааны (2), шүдний (2), эмэгтэйчүүдийн (1) клиник шинээр нээж, үйл ажиллагааг эхлүүлсэн.</p> <p>Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйлчлэх хүрээ, байршлыг хүн амын эрүүл мэндийн байдал, хэрэгцээтэй уялдуулан дахин тооцоолж, 2 өрхийн эрүүл мэндийн төв шинээр байгуулах асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, ИТХ-ын 2025 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 03/47 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>Тайлант хугацаанд Орхон аймагт мал бүхий 821 иргэн хөдөө өвөлжиж байгаагаас эрсдэлт бүлэгт</p>

							<p>хамаарах 371 иргэний судалгааг гарган, 35–120 км-ийн үйлчилгээний радиусыг тогтоон газарзүйн зураглал боловсруулсан.</p> <p>“Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд орон нутгийн 75.0 сая төгрөгийн санхүүжилтээр Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн түргэн тусламжийн 103 дуудлагын үйлчилгээний програм хангамжийг шинэчлэх сонгон шалгаруулалтыг 2025 оны 02 дугаар сарын 14-нд зарлаж, “Эгософт” ХХК шалгарснаар гүйцэтгэлийг хугацаанд нь 100 хувь хийж дуусгасан. Үүний үр дүнд БОЭТ-ийн албан ёсны цахим сайтын танилцуулга, үйлчилгээний заавар бүхий нийтлэлийн хандалт 2 дахин нэмэгдэж, иргэдийн эрүүл мэндийн мэдээлэл авах хүртээмж сайжирсан.</p> <p>Мөн жирэмслэлт болон 3 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн хяналт, нэгдсэн эмнэлгийн үйлчилгээ, эмчийн цаг захиалга, түргэн тусламжийн дуудлагын 2 төрлийн гар утасны аппликейшн хөгжүүлэлтийн шатанд хэрэгжиж байгаа бөгөөд эмчийн цаг захиалах системийг турших явцад хүлээгдэл 30 хувиар буурч, жирэмсэн эхчүүдийн мэдээлэл авах хүртээмж нэмэгдсэн эерэг үр дүн гарсан байна.</p>
10	2.2.12.Төр, хувийн иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцүүлж хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй “Үйлчлүүлэгч төвтэй” тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий	ОНТ 30.0	Оношилгооны чадавхын хувь	2023	90%	90,2% ЭТҮХ Хишгээ	<p>Хувийн хэвшлийн 1 нэгдсэн эмнэлэг, 11 ор бүхий клиникүүдтэй аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллалаа. Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 56200 үзлэг хийсэн нь аймгийн хэмжээнд хийгдсэн нийт үзлэгийн 13,9%-ийг, 9989 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн нь нийт эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчийн 53,2%-ийг эзэлж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн ачааллыг хуваалцсан байна. Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний нэр төрөл 3-аар нэмэгдсэн байна. Хувийн хэвшлийн төрөлжсөн эмнэлэг 1,</p>

	эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжинэ.						<p>хүүхдийн 4 клиник томуу томуу төст өвчний үеийн тусламж үйлчилгээний ачаалал, хүлээгдлийг бууруулах чиглэлээр уртасгасан цагийн зохицуулалт хийж хамтран ажилласан. Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад 6 хувийн хэвшлийн нөхөн үржихүйн клиниктэй гэрээ байгуулан 16-49 насны 942 эмэгтэйг үзлэгт хамруулан 38.5 хувийг бүрэн эмчлэн эрүүлжүүлэн, лавлагаа шатлалд 374 эмэгтэйг илгээсэн байна. Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувиллыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийг шийдвэрлэн, сульдаа, уураг илчлэгийн дутагдал, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 80 хүүхдийг нар ус агаараар чийрэгжүүлэх зуны сувиллын үйл ажиллагааг Бүжинлхам хувийн хэвшлийн клиник гүйцэтгэж байна.</p> <p>Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд оношилгооны чадавхыг сайжруулж, оношилгооны чадавх 91%-тай байна.</p>
11	2.2.13.Оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэд эх орондоо бүрэн оношлогдон эмчлэгдэх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ гадаадын иргэд манай оронд ирж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмнэлэг олон улсын магадлан итгэмжлэл авах үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.		Нэвтрүүлсэн шинэ төрлийн технологийн тоо	2023	3	3	<p>Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (БОЭТ)-ийн тоног төхөөрөмжийн хангалт 96 хувь, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хангалт 92.5 хувьтай байна. БОЭТ нь нийт 600 гаруй шаардлагатай болон нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан бөгөөд үүнээс 20.1 хувь нь дэвшилтэт технологийн төхөөрөмжүүд эзэлж байна.</p> <p>Хавдрын төвд 602.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлснээр тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, зүрхний титэм судасны ангиографийн оношилгоо, эмчилгээ 406, элэгний хавдрын тэжээгч судас бөглөх эмчилгээ 44, тархины судасны оношилгоо, эмчилгээ 34, зүрхний хэм алдагдлын байнгын суулгац 1, хавдрын хими эмчилгээний үеийн венийн судасны порт 12 тохиолдолд тус тус хийгдсэн.</p>

						<p>БОЭТ-ийн түргэн тусламжийн дуудлага, цаг товлолын үйл ажиллагааг цахимжуулахад аймгийн төсвөөс 75.0 сая төгрөг зарцуулж, амбулаторийн тасгийн цахим бүртгэлийн системийг бүрэн нэвтрүүлсэн. Харвалт, шигдээсийн төвөөр дамжуулан зүрхний титэм судсан дотуурх мэс заслыг 406, тархины судасны оношилгоо, эмчилгээг 24, элэгний хавдрын бөглөх ажилбарыг 44 хүнд хийсэн байна.</p> <p>Амьсгалын хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 23 нярайд сурфактант эмчилгээ хийж, 82.6 хувийн үр дүн үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар өссөн байна. Мөн мухар олгойг дурангаар авах мэс заслыг 11 хүнд, шээлгүүрийн дурангаар стент тавих, чулуу авах 2 үе шаттай мэс заслыг 5 хүнд амжилттай нэвтрүүлэн хийсэн.</p> <p>Тайлант хугацаанд төрсөн 1435 нярайд нярайн тандалт, скрининг шинжилгээнд 100 хувь хамруулсан. Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь 2024 онд үйлдвэрлэгдсэн GEE6 өндөр нягтралтай ургийн эхо аппаратаар жирэмсний 11 долоо хоногоос ургийн гажиг илрүүлэх оношилгоог 237 жирэмсэн эхэд хийсэн. Мөн дэлхийд тэргүүлэх компанийн MRI, CT аппаратаар 1025 иргэнд үйлчилгээ үзүүлж, тархины судасны доплерийн чиглэлээр 76 иргэнд оношилгоо хийсэн.</p> <p>ӨЭМТ-үүд 5 төрлийн шинэ лабораторийн шинжилгээг нэвтрүүлж, нийт 55,060 лабораторийн тусламж үйлчилгээ үзүүлснээс 99.8 хувь нь төлбөргүй байж, өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хувийн хэвшлийн Баян-Өндөр Мед эмнэлэг хиймэл оюун ухаанд суурилсан “CerviCare AI” системийг нэвтрүүлж, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлгийг 1452 хүнд хийж, 36 хүнийг онош тодруулан эмчилгээнд хамруулсан. Мөн RMC эмнэлэгтэй хамтарсан</p>
--	--	--	--	--	--	--

							үргүйдлийн оношилгооны кабинетаар 73 иргэнд үзлэг хийж, 32 хүнийг лавлагаа шатлалд илгээсэн байна.
12	2.2.14. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.		Хэрэгжилтийн хувь	2023	78%	80%	<p>Тайлант хугацаанд зонхилон тохиолдох халдварт бус өвчний 5 төрлийн эрт илрүүлэгт 136,861 хүнийг хамруулахаар төлөвлөснөөс 115,748 хүн хамрагдаж, хамрагдалтын түвшин 84.5 хувьтай гарсан нь өмнөх оны мөн үеэс 3.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Артерийн гипертензийн эрт илрүүлгийн үзлэгт 18-аас дээш насны 49,835 хүн хамрагдсан нь хамрагдвал зохих хүн амын 78.6 хувийг эзэлж, өмнөх оноос 15.7 хувиар буурсан үзүүлэлттэй бөгөөд үзлэгийн үр дүнд 0.7 хувьд онош батлагдсан байна. Чихрийн шижингийн эрт илрүүлэгт 35-аас дээш насны 41,471 хүн хамрагдсан нь зорилтот бүлгийн 100.2 хувийг эзэлж, өмнөх оноос 13.4 хувиар өссөн бөгөөд 0.4 хувьд онош батлагдсан байна.</p> <p>Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт зорилтот насны 3,213 эмэгтэй хамрагдаж, хамрагдалт 55.7 хувьтай, өмнөх оны мөн үеэс 37.7 хувиар буурсан байна. Хийгдсэн 2,913 шинжилгээнээс 2,627 буюу 90.2 хувь нь хэвийн гарсан. Хөхний хорт хавдрын эрт илрүүлэгт 19,236 эмэгтэй хамрагдаж, хамрагдалт 78.7 хувьтай, өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар буурсан байна. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт зорилтот бүлгийн 40–65 насны 1,993 хүн хамрагдсан нь төлөвлөгөөний 107.3 хувийг эзэлж байна.</p> <p>Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлгийн санаачилга, ХААН Банк Сангийн санхүүжилттэй “Цусны даралт ихсэлтийн эсрэг аян–2025” нь 8 дахь жилдээ хэрэгжиж байгаа бөгөөд Орхон аймагт хоёр дахь удаагаа 5 хоногийн хугацаанд зохион байгуулагдлаа. Аяны</p>

							хүрээнд эрүүл мэндийн боловсрол, сургалт, артерийн гипертензийн зөвлөгөөнд 1,171 хүн, бие бялдрын бүрдмэл үнэлгээнд давхардсан тоогоор 3,960 хүн, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөөнд 2,123 иргэн хамрагдаж, шаардлагатай эмчилгээ, зөвлөмж авсан байна.
13	2.2.15. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний үеийн тусламж, үйлчилгээг сайжруулах зорилгоор олон улсын жишигт нийцсэн төвийг төрөлжүүлэн байгуулна (Зүрх судасны төв, Эрхтэн шилжүүлэн суулгах төв, Яаралтай тусламжийн үндэсний төв гэх мэт).		Тархины харвалт, шигдээсийн чиглэлээр шинэ дэвшилтэт технологийг нутагшуулах	2023	Тархины харвалт, шигдээсийн чиглэлээр шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн байх	Тархины харвалт, шигдээсийн чиглэлээр шинэ дэвшилтэт технологийг нутагшуулсан байх	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн мэдрэл, дотор, эрчимт эмчилгээний тасгуудад тархины харвалтын үеийн бүлэн хайлуулах эмчилгээг нутагшуулж, уг эмчилгээг гүйцэтгэхээр 1 эмч, 1 сувилагчийг мэргэшүүлэн сургаж бэлтгэсэн. БОЭТ-ийн захирлын тушаалаар Тархины харвалтын нэгж байгуулж, мэдрэлийн тасагт 2 ор, эрчимт эмчилгээний тасагт 2 ор, дотрын тасагт харвалтын тусгай нэгжийг тус тус зохион байгуулсан.  Тайлант хугацаанд судас дотуурх оношилгоо, эмчилгээг 62 иргэнд амжилттай хийж, амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх бодит үр дүн гарсан. Уг өндөр өртөг бүхий оношилгоо, эмчилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд дунджаар 4.9 сая төгрөгөөр санхүүжүүлж, иргэдэд үзүүлэх санхүүгийн ачааллыг бууруулан ажиллаж байна.
14	2.2.16. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулна.		Арга хэмжээний хэрэгжилт 30 хувь	2023	82,5%	83%	Орхон аймагт нөхөн үржихүйн насны 24,027 эмэгтэй, үүнээс зорилтот бүлгийн 1,611, хөгжлийн бэрхшээлтэй 676 эмэгтэй байна. Тайлант хугацаанд нийт эмэгтэйчүүдийн 58.4 хувь, зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн 74 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагдсан.  Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн дунд бэлгийн замын халдвар илрүүлэх шинжилгээнд 2,203 эмэгтэй хамрагдаж, тэмбүүгийн 8, трихомониазын 1 эерэг тохиолдлыг илрүүлэн хавьтлын хамт эмчилж, бүрэн эрүүлжүүлсэн. Мөн 1,496 эмэгтэйг эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт, 711 охидыг эхо шинжилгээнд хамруулж, 192 өвчлөлийг илрүүлэн эмчилсэн. 5 ерөнхий боловсролын

							<p>сургуулийн 439 охидод эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэж буй 16,297 эмэгтэй (65.1%) байгаа нь өмнөх оноос 419 тохиолдлоор нэмэгдсэн байна. Хэрэглээний төрлөөр авч үзвэл жирэмслэхээс хамгаалах эм 17.8%, тариа 9.4%, суулгац 4.9%, бэлгэвч 28.2%, ерөндөг 30.2%, гуурсан хоолой боох 2.3%, бусад 7.2%-ийг тус тус эзэлж байна.</p> <p>Тайлант хугацаанд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 13 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 6 тохиолдлоор буурсан үзүүлэлт бөгөөд эндэгдлийн 92.3 хувь нь нялхсын эндэгдэл байна. Нялхсын эндэгдлийг бууруулах 3 бүлэг, 13 арга хэмжээтэй төлөвлөгөөг хэрэгжүүлж, хэрэгжилт 93.4 хувьтай байна. ЭМГ-ын дэргэдэх Магадлан хэлэлцэх зөвлөл 3 удаа хуралдаж, амьгүй төрөлт 8, гэрийн төрөлт 1, эхийн ноцтой хүндрэл 2, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 12 тохиолдлыг хэлэлцэн дүгнэлт, зөвлөмж гаргасан.</p> <p>Зорилтот бүлгийн суурь өвчтэй, сульдаа 100 хүүхдийг чийрэгжүүлж, 82.4 хувьд жин, өсөлтийн үзүүлэлт сайжирсан. Нийгмийн халамж нэн шаардлагатай 535 жирэмсэн, хөхүүл болон зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд “Жентли Айрон” төмрийн бэлдмэл, 989 жирэмсэн эмэгтэйд ОНБТБ-ийн эхний 2 сарын хэрэглээг олгосон.</p> <p>Сэргийлж болох эндэгдлийг бууруулах чиглэлээр 390 жирэмсэн эх, тэдний гэр бүлийг хамруулсан сургалт, мэдээллийн үйл ажиллагаа зохион байгуулж, 395 ширхэг гарын авлага, 6 видео контент (7,690 хандалт), 4 постер (25,196 хандалт) түгээсэн байна.</p>
15	2.2.17.Яаралтай түргэн тусламжийн үндэсний тогтолцоог шинэчлэн	ОНТ 385.0	Яаралтай дуудлагад 20 минутын дотор	2023	100%	100%	Аймгийн хэмжээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн түргэн тусламжийн тасаг нь туулах чадвар сайтай, бүрэн тоноглогдсон 2, хагас тоноглогдсон

	өөрчилж, онгоц, агаарын тээврийн үйлчилгээг тусламж, үйлчилгээнд нэвтрүүлнэ.		очсон хувь				<p>10, нийт 12 автомашинаар яаралтай дуудлагад үйлчилж байна. Түргэн тусламжийн үйл ажиллагааны зардалд орон нутгийн төсвөөс 385 сая төгрөг шийдвэрлэн, үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлсэн.</p> <p>Тайлант хугацаанд нийт 12,091 дуудлага хүлээн авснаас 3,997 (33%) нь яаралтай, 90 (0.7%) нь алсын, 143 (1.2%) нь үр дүнгүй дуудлага байна. Нэн яаралтай дуудлагад 20 минутын дотор очсон хувь 75.3% байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Хэдий тийм боловч 41 минутаас дээш хүлээгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.4 хувиар буурсан эерэг үзүүлэлт ажиглагдсан. Хариу очих хугацаанд нөлөөлсөн хүчин зүйлсэд орон нутагт зам засварын ажил эхэлж автомашины түгжрэл нэмэгдсэн, мөн Дэнж багийн бүсэд 16:00–24:00 цагийн хооронд ажиллаж байсан нэмэлт жолооч, эмчийг буулгасантай холбоотой зохион байгуулалтын өөрчлөлт нөлөөлсөн байна.</p>
16	2.2.18. Иргэд эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийн улмаас санхүүгийн эрсдэлд орохоос сэргийлэх боломжтой бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	ОНТ	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2023	80%	81%	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуусыг сэргээн засах, хөгжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргатай 7 төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, төвүүдийн үйл ажиллагааг дэмжихэд 242 сая төгрөг шийдвэрлэснээр үйлчилгээ тасралтгүй, хэвийн явагдаж байна. Мөн орон нутгийн төсвөөс 30 сая төгрөг шийдвэрлэн “Бүжинлхам” хүүхдийн чийрэгжүүлэх сувилалд хөгжлийн бэрхшээлтэй болон суурь өвчтэй 100 хүүхдийг хамруулах ажлыг эхлүүлээд байна.</p> <p>Хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан, 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй, ажил хөдөлмөр эрхэлдэггүй эцэг эх, асран хамгаалагчдын нийгмийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс төлөх боломжийг бүрдүүлж, 247 иргэн хамрагдсан.</p> <p>Орон нутгийн төсвийн 2.0 сая төгрөгийн</p>

							<p>дэмжлэгээр 1,496 эмэгтэйг (92.8%) үзлэг, оношилгоонд хамруулж, бэлгийн замын халдвар илрүүлэх шинжилгээнд 812 эмэгтэй, эхо оношилгоонд 711 эмэгтэй хамруулан, 192 эмэгтэйд (13%) өвчлөл илрүүлж, эмчилгээ, хяналтад авсан.</p> <p>Мөн Эх, хүүхдийн үндэсний төвийн хүүхдийн поликлиникийн нарийн мэргэжлийн 19 эмчийн баг аутизм, тархины саа, уналт таталт, эпилепси, тархины усжилт зэрэг оноштой 33 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд иж бүрэн үзлэг, зөвлөгөө үзүүлсэн.</p> <p>“Хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн болон ахмад настнуудыг үзлэг, оношилгоо, сэргээн засах дасгал хөдөлгөөн эмчилгээнд хамруулах” үйл ажиллагааны хүрээнд 2,466 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд давхардсан тоогоор 13,115 удаагийн урт болон богино хугацааны сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.</p>
17	2.2.19.Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас олгох зардлын ялгааг үе шаттайгаар арилгана.		Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	2023	73,5%	75%	<p>Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс эрүүл мэндийн даатгалгүй иргэдийг даатгалд хамруулах ажлыг өрнүүлэн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын шинэчлэгдэн батлагдсан тогтоолуудын мэдээллийг иргэдэд хүргэн ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд эрүүл мэндийн даатгалыг төр хариуцдаг даатгуулагч 72711, албан журмын даатгуулагч 24477 иргэн хамрагдаж, хамрагдалт 100% байна.</p>
18	2.2.20.Төрийн өмчийн эмнэлгийн санхүүжилтийн болон удирдлагын бие даасан хэлбэрт шилжүүлэх үйл		<u>БОЭТ-ийг</u> санхүүжилт болон удирдлагын бие даасан	2023	-	Бие даасан хэлбэрт шилжсэн байна.	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйл ажиллагааны ил тод, үр ашигтай удирдлагыг хангах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан. Тайлант хугацаанд тус зөвлөл нийт 4 удаа

	ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.		хэлбэрт шилжсэн байна.			УТХ Чулуун-Эрдэнэ Отгондэлгэр	<p>хуралдсан бөгөөд үүнээс 2 удаагийн хурал цахимаар, 2 удаагийн хурал танхимаар зохион байгуулагдсан.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/414 дугаар тушаалын дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захиралын нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг хийж, зарлалыг 2025 оны 11 сарын 12–28-ны өдрүүдэд Эрүүл мэндийн яам болон Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулан сонгон шалгаруулалтын явцыг зохион байгуулж, шаардлагын дагуу дүнг нэгтгэн Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Эрүүл мэндийн яамны сайдын 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр батамжлах тухай” Б/76 дугаар тушаалаар тус төвийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдхүүнийг 9 гишүүнтэйгээр баталсан байна. Үүнд: Өмчлөгчийг төлөөлөх бүрэлдхүүнээр ЭМЯ, Сангийн яам, Эрүүл мэндийн даатгалын газрын төлөөлөл, тухайн эмнэлгийн хамт олныг төлөөлж 3 ажилтан, олон нийтийг төлөөлж төрийн бус байгууллагаас 2, мэргэжлийн салбар нийгэмлэгээс 1 нийт 9 гишүүнийг баталсан байна.</p>
19	2.2.21. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор төрөөс хараат бус бие даасан магадлан итгэмжлэлийн тогтолцоог бүрдүүлнэ.		Магадлан итгэмжлэлд хамрагдсан байгууллагын хувь	2023	100%	100%  ЭТҮХ Хишгээ	<p>Эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэлд хамрагдсан бүртгэл судалгааг тогтмол шинэчил ажилласан.</p> <p>2024 оны эхний 7 сарын байдлаар магадлан итгэмжлэлд хамрагдсан 25 эрүүл мэндийн байгууллага байна.</p> <p>Тайлант хугацаанд сум, өрхийн эрүүл мэндийн 7 төв, Мөнхийн үйлс ортой клиник магадлан итгэмжлэлд орж, магадлан итгэмжлэлийн хугацааг 2 жилээр сунгуулсан. “Мишээл” клиник, сэтгэц наркологийн “Оюу” клиник, “Шинэ эрин мед” клиник, “Нейрон” клиник 2024 онд магадлан итгэмжлэлд хамрагдахаар бэлтгэл ханган ажиллаж байна. мэндийн байгууллагуудын “Чанар</p>

							аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө"-ний хэрэгжилт дунджаар 90%-тай байна.
20	2.2.22. Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг бүрэн нэвтрүүлнэ.		Тусламж үйлчилгээний нэр төрөл	2023	11	12 ЭТҮХ Хишгээ	Тайлант хугацаанд магадлан итгэмжлэгдсэн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас олгох зардлын ялгаа арилсан. Оношийн хамааралтай бүлгээр санхүүжиж байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 419 оношийн хамааралтай бүлгээр сонгон шалгаруулалтад тэнцэж, ЭМДЕГ-тай гэрээ байгуулан санхүүжилт авч байна. Хувийн хэвшлийн ор бүхий 8 клиник амбулатори, өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээгээр эрүүл мэндийн даатгалын сонгон шалгаруулалтад тэнцэж, 115 оронд өдрийн эмчилгээ хийж байна. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 05 дугаар тогтоолоор анхан шатны эрүүл мэндийн байгууллагаар үзүүлэх боломжтой оношийн бүлгийг 18 нэр төрлөөр нэмэгдүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийт 15378 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлснээс 3321 иргэнд сэргээн засах тусламж үйлчилгээ, 742 иргэнийг гэрийн эмчилгээнд, 1662 иргэнийг өдрийн эмчилгээнд, 9653 иргэнд оношилгоо шинжилгээний тусламж үйлчилгээг үзүүлж 694.4 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг багцын үзлэгийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр хийж байна. Нийтийн үйлчилгээтэй эмийн сангийн тоо 77 байгаагаас 54/70,1%/ эмийн сан ЭМДС-тай гэрээ байгуулан ажиллаж Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй эмээр үйлчилсэн. Элэгний В вирусийн эсрэг эмэнд 5 нэрийн эмийг 40-50% хөнгөлж байна. Новартисын 16 нэр төрлийн 24 эмийг иргэдэд Орхон аймагт Монос, Орхон эм хангамж, Ази фарм эм, ханган нийлүүлэх байгууллагаас нийтдээ 18 эмийн сангаар дамжуулан иргэдэд 100% үнэ төлбөргүй олгож байна. Тайлант хугацаанд 6 төрлийн тусламж үйлчилгээ нэмэгдсэн ба уламжлалт анагаах

							ухааны чиглэлээр клиникүүдэд нэр төрөл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.5%-аар өссөн үзүүлэлттэй байна.
21	2.2.23. Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж экспортод гарах гарцыг дэмжин “брэнд” болгоно.	ОНТ	Үйл ажиллагааны тайлан, хэрэгжилтийн хувь	2023	82%	82,5%	<p>Тайлант хугацаанд уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг 89267 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,2%-иар нэмэгдсэн байна.</p> <p>Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг аймгийн хэмжээнд бүх шатлалын төр болон хувийн хэвшлийн нийт 26 Эрүүл мэндийн байгууллага үзүүлж байгаа бөгөөд тусламж үйлчилгээний хүртээмжийг үнэлж үзэхэд сум, өрхийн эрүүл мэндийн 9 төв 12587 буюу 14,1%, БОЭТ 1212 буюу 1,3 %, Эрдэнэт сувиллын цогцолбор 4978 буюу 7,3%, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 61490 буюу 68,8%-д уламжлалт анагаах ухааны тусламжийг үзүүлсэн байна.</p> <p>Эмч нарыг чадавхжуулах хүрээнд:  “МУАУ-ны хувь хүний өвөрмөц чанарыг хэрхэн тодорхойлох вэ, идээ ундаа явдал мөрийн аргаар өвчнөөс сэргийлэх арга”, “Нурууны өвдөлт үүсэхэд нөлөөлж буй буруу дадал хэвшлүүд” “Уламжлалт анагаах ухааны эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах эмнэл зүйн сургалт” “Косметик зүү эмчилгээ хийх ур чадвар эзэмшүүлэх” “Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал” сэдэвт сургалтуудыг танхимаар зохион байгуулж давхардсан тоогоор 221 эмч хамрагдсанаар өмнөх оны мөн үеэс 2,1%-иар нэмэгдсэн байна.</p> <p>“Алтан тун-2025” өдөрлөгийг анх удаа Орхон аймагт зохион байгуулж, 22 эрүүл мэндийн байгууллагын 58 мэргэжилтэн, 180 иргэн оролцож, уламжлалт анагаах ухааны үзлэгт 120, нурууны үзлэгт 85, 3 наснаас дээш хүүхдийн хөлийн нумны үзлэгт 15 иргэн хамрагдав. Өдөрлөгөөр байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахад уриалж, урьдчилан сэргийлэх дадал зуршлыг төлөвшүүлэх, мэргэжилтнүүдийн</p>

							чадавхийг сайжруулахад үр дүнтэй зохион байгуулагдсан. Үйл ажиллагааны хэрэгжилт 98%-тай байна
22	2.2.25. Эмчилгээ, оношилгоо, сургалтад алсын зайн анагаах ухааныг (теле медицин) өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх түвшинд ашиглаж хэвшинэ. Алслагдсан сумын эрүүл мэндийн төвөөс холбогдож үйлчлүүлэгч зөвлөгөө авах боломжийг бүрдүүлнэ.		Алсын зайн оношилгоо, телемедицин нэвтэрсэн байгууллагын тоо	2023	10	11	<p>Тайлант хугацаанд зүрх судасны өвчний тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор mn.Cardio үндэсний программын цахим өвчний түүхэнд 115 иргэний мэдээллийг оруулж, оношилгоо, хяналтын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлсэн. БНСУ-ын Бусан хотын Үндэсний их сургуулийн эмнэлгийн алсын зайн оношилгоо, эмчилгээний төв Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 2023 онд байгуулагдсанаас хойш тайлант хугацаанд 18 өвчтөнд нарийн мэргэжлийн зөвлөгөө авсан байна.</p> <p>Алслагдсан бүсийн иргэдэд тусламж, үйлчилгээ ойртуулах хүрээнд Жаргалант сумын эрүүл мэндийн төвөөс эмнэлзүйн хүнд өвчтөнд авах арга хэмжээний зөвлөмжийг БОЭТ-ийн нарийн мэргэжлийн, мэргэшсэн эмч нараас телемедицинээр авах боломжийг бүрдүүлсэн. Мөн байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хэвтрийн иргэдийг Эмнэлэг, хөдөлмөр магадлах комиссын хуралд телемедицинээр гэрээсээ өрхийн эмчийн хамт оролцуулах зохион байгуулалтыг хийж, иргэдийн цаг, зардлыг хэмнэсэн.</p> <p>“Цахим Эрдэнэт–1” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг 20 ширхэг таблетаар хангаж, түргэн тусламж болон гэрийн эргэлт, дуудлагаар очих үед эмч нар өвчтөний цахим өвчний түүхийг газар дээр нь харах, үзлэгийн бүртгэл хийх, хөнгөлөлттэй эмийн жор бичих боломж бүрдсэн.</p> <p>Одоогоор Жаргалант сумын эрүүл мэндийн төв болон 5 өрхийн эрүүл мэндийн төвд мобайл технологид суурилсан телемедицин нэвтэрч, тайлант хугацаанд 50 өвчтөний мэдээллийг алсын</p>

							зайн технологиор дамжуулан оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авсан байна. Аймгийн хэмжээнд алсын зайн оношилгоо, телемедицинский техник тоног төхөөрөмжтэй 11 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна.
23	2.2.26. Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээнд үндэслэн эрүүл мэндийн технологийн төлөвлөлт, ашиглалт, нэвтрүүлэлт, чанарын хяналт, засвар үйлчилгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.		Ашиглалтын хувь	2023	90,7%	90,8%	<p>Эрүүл мэндийн байгууллагуудад удирдамж бүхий хяналт, үнэлгээ хийсний дүнд стандартын шаардлагад нийцүүлэн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт дунджаар 95.5 хувь, ашиглалт 87.5 хувьтай байна. Үүнийг байгууллагын төрлөөр авч үзвэл Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 96 хувь, ашиглалт 93 хувь, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн хангалт 92 хувь, ашиглалт 90 хувь, Эрдэнэт клиник, сувиллын тоног төхөөрөмжийн хангалт 85 хувь, ашиглалт 96 хувьтай байна.</p> <p>Аймгийн хэмжээнд Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр Мед нэгдсэн эмнэлэг, Талын Булаг клиникт эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер үндсэн орон тоогоор ажиллаж байгаа бөгөөд гэрээний үндсэн дээр сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв, хувийн хэвшлийн ортой клиник зэрэг нийт 26 байгууллагын багаж, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспортыг тогтмол хөтлөн, урсгал засвар, техникийн үнэлгээг хуваарийн дагуу хийж байна.</p> <p>Тайлант хугацаанд тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний баталгаажилт 94.5 хувьтай хэрэгжсэн.</p>
24	2.2.27. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш,	УТ 1,2 тэрбум  ОНТ 5,9	Стандартын шаардлага хангасан барилга байгууламжтай ЭМБ-ын хувь	2023	100%	100%	<p>Тайлант хугацаанд нийт 7,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж Барилга, их засварт 2,8 тэрбум буюу 39, %, Тоног төхөөрөмж 1,9 тэрбум буюу 27,8%, Төсөл хөтөлбөрт 2,3 тэрбум буюу 32,6% тус тус эзэлж байна. Үүнд:</p> <p>1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,2 тэрбум төгрөгөөр иж бүрэн мэс заслын 2 Вакуум</p>

	хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	тэрбум					хагалгааны өрөөг, тоног төхөөрөмжийн хамт ашиглалтад оруулсан. Уг өрөөг орчин үеийн вакуум өрөө болгож тохижуулснаар мэс заслын дараах үеийн шарх эдгэрэлт, халдвар хамгаалал сайжирч өвчтөний аюулгүй байдал, ажилчдын тав тухтай орчинд мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлэн ажилласан. 2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар: БОЭТ-ийн Хавдрын оношилгоо, эмчилгээний төвийн их засвар - 350,0 сая, Мэндцэцэн өрхийн эмнэлгийн гадна шугамыг засварлах - 196,7 сая, Хүрэнбулаг багийн Анхны-Оч өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын дээврийн болон дотор засвар - 253.0 сая, Дэнж багийн Учралтбаяр өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын гадна фасадны засвар - 160,0 сая, БОЭТ-ийн Хагалгаа ариутгалын нэгдсэн тасгийн дээврийн засварт - 89,9 сая, БОЭТ-ийн гемодиализийн тусламж үйлчилгээг үзүүлэх өрөөнүүдийн засвар -593,0 сая төгрөгийн их засварын ажлууд тус тус их засварууд хийгдэж 100 хувь ашиглалтад орж иргэдийн тав тухтай, орчин бүрдүүлэн ажиллаж байна.
25	2.2.28. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.	УТ 602,0 ОНТ 205,0	БОЭТ-ийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь  СӨЭМТ-ийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	2023	90%  95%	95%  95,1%	айлант хугацаанд Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (БОЭТ)-ийн тоног төхөөрөмжийн хангалт 95 хувь, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хангалт 96 хувьтай байна. БОЭТ нь нийт 600 гаруй шаардлагатай болон нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан бөгөөд үүнээс 20.1 хувь нь дэвшилтэт технологийн төхөөрөмж эзэлж байна.  Хавдрын төвд 602.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлснээр тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, зүрхний титэм судасны ангиографийн оношилгоо, эмчилгээ 406, элэгний хавдрын тэжээгч судас бөглөх эмчилгээ 44, тархины судасны оношилгоо, эмчилгээ 34, зүрхний хэм алдагдлын байнгын суулгац 1, хавдрын хими эмчилгээний үеийн венийн судасны порт 12 тохиолдолд тус тус хийгдсэн байна.

						<p>Түргэн тусламжийн 11 автомашинаас 3 нь бүрэн, 6 нь хагас тоноглогдсон бөгөөд гүйлтийн дээд хязгаар хэтэрсэн 2 автомашинд судалгаа хийж, цаашид шинэчлэх шаардлагатайг тогтоосон. БОЭТ-ийн хүлээн авах болон хэвтэн эмчлүүлэх тасгуудад хийсэн төлөвлөгөөт бус хяналтаар илэрсэн 6 нэр төрлийн тоног төхөөрөмжийн дутагдлыг арилгах зорилгоор орон нутгийн төсвөөс 130.0 сая төгрөг шийдвэрлэж, шаардлагатай төхөөрөмжүүдийг яаралтай тусламж болон хүүхдийн тасгуудад байршуулан, ажлын орчныг сайжруулж, иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн.</p> <p>БОЭТ-ийн түргэн тусламжийн дуудлага, цаг товлолын үйл ажиллагааг цахимжуулахад аймгийн төсвөөс 75.0 сая төгрөг зарцуулж, амбулаторийн тасгийн цахим бүртгэлийн системийг бүрэн нэвтрүүлсэн бөгөөд түргэн тусламжийн дуудлагын хэсэг туршилтын горимоор ажиллаж байна.</p> <p>Өрхийн эрүүл мэндийн төвүүд 5 төрлийн шинэ лабораторийн шинжилгээг нэвтрүүлж, цусны дэлгэрэнгүй, шээсний ерөнхий шинжилгээ, биохимийн 14 үзүүлэлт, иммунологийн түргэвчилсэн 6, тоон үзүүлэлтээр 5 төрлийн шинжилгээг хийж, нийт 55,060 лабораторийн тусламж үйлчилгээ үзүүлснээс 99.8 хувь нь төлбөргүй байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар өссөн үзүүлэлт юм.</p> <p>Хувийн хэвшлийн Баян-Өндөр Мед эмнэлэг хиймэл оюун ухаанд суурилсан “CerviCare AI” системийг нэвтрүүлж, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт 822 иргэнийг хамруулан, 187 урьдал үеийн өөрчлөлт илрүүлж, үүнээс 22 иргэнийг эмчилгээнд хамруулсан. Мөн үргүйдлийн оношилгооны кабинетаар 73 иргэнд үзлэг хийж, 32 иргэнийг лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ</p>
--	--	--	--	--	--	---

							рүү илгээсэн байна.
26	2.2.29. Хүн амын хэрэгцээ, тусламж үйлчилгээний зохион байгуулалт төлөвлөлттэй уялдуулан хүний нөөцийг бэлтгэж, орон нутгийн хэрэгцээг хангаж, эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгон бодит цалингийн хэмжээг улсын дунджаас дээш байлгана.		Хүний нөөцийн хангалтын хувь	2023	85%	86%  ЭТҮХ Бямбасүрэн	<p>2025 онд “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд эрүүл мэндийн салбар 2 зорилт, 7 үйл ажиллагаа, 15 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>2025 оны байдлаар нийт эрүүл мэндийн салбарт 2089 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс 474 их эмч, 515 сувилагч ажиллаж байна.</p> <p>Төрийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 60 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцсанаас улсын төсвийн санхүүжилтээр 16 эмч эмнэлгийн мэргэжилтэн буюу 26,6% нь суралцсан.</p> <p>Орон нутагт нэн шаардлагатай 18 эмч нарыг багаар нь гадаад болон дотоодын сургалтад 74.3 сая төгрөгний дэмжлэг үзүүлэн сургасан байна.</p> <p>Үүнд: Өвдөгний үений мэс засал судлал, Эмэгтэйчүүдийн хавдар судлал, Ходоод, нарийн гэдэсний хавдрын мэс засал судлал, Хөх, улаан хоолойн хавдрын мэс засал судлал, Эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал судлал, эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал судлал, хавдрын сувилагч, хөнгөвчлөх эмчилгээний сувилагчийг бэлтгэж байна.Төлөвлөлтийн дагуу нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийн эзлэх хувь 92% байна</p> <p>Тайлант хугацаанд шинээр 22 эмч, сувилагч Орхон аймагт шилжин ирж ажиллаж байна.</p> <p>Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн салбарын төрийн захиргааны албан хаагчдын цалин 12%, Засгийн газрын 2022 оны 489 дугаар тогтоолоор орон нутагт ажилласны нэмэгдэл 20%, 2022 оны 491 дугаар тогтоолоор төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тус тус олгосон. Эрүүл мэндийн байгууллага бүр албан хаагчдын үр дүнг сар бүр үнэлж, урамшууллыг улирал тутам олгож ажилласан.</p> <p>Цалин, шагнал урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсвийн 72,97%-ийг эзлэж</p>

							байна. Тайлант хугацаанд цалин шагнал урамшуулалд Бүсийн оношилгоо эмчилгээний төв 75.75%, Жаргалант сумын эрүүл мэндийн төв нь 62,93%-ийг, Эрүүл мэндийн газар нь 74,54%-ыг тус тус зарцуулсан бөгөөд төрийн байгууллагын цалин шагнал урамшуулалд байгууллагын нийт төсвийн дунджаар 71,07%-ийг зарцуулсан байна.
27	2.2.30. Эрүүл мэндийн чиглэлээр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, үйл ажиллагааг боловсронгуй болгоно.		Төслийн хэрэгжилтийн хувь	2023	100%	100%	Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2021 оны 15-р тогтоолоор “Яаралтай тусламжийн сувилахуй”, “Эрчимт эмчилгээний сувилахуй” чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрлийг олгосноор орон нутагт сувилахуйн төгсөлтийн дараах сургалт эрхлэх анхны эрүүл мэндийн байгууллага болсон. Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалт 4 дэх жилдээ амжилттай хэрэгжиж, 2025 онд “Эрчимт эмчилгээний сувилахуй” 3, “Яаралтай тусламжийн сувилахуй” 13 сувилагч төгсөж, суралцагчдын тоо өмнөх оноос 40%-р нэмэгдсэн. Монгол Улсад анх удаа “Шинэ сувилагчийг дадлагажуулах жишиг хөтөлбөр” батлагдан манай аймаг 2 дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж, 2025 онд 7 байгууллагын 8 сувилагчийг хамруулсан. Сургалтын үр дүн: Шинэ сувилагчдын ажлын байрны тогтвор суурьшил нэмэгдэж, өөртөө итгэх итгэл, сэтгэл зүйн үнэлгээ, мэдэрч буй стрессийн түвшин тогтвортой болж, гардан үйлдлийн ур чадварын үнэлгээ 22,9%-иар нэмэгдсэнээр сувилахуйн тусламж үйлчилгээний чанар сайжирсан. Мөн АШУҮИС, Монгол-Япон эмнэлэгтэй хамтран “Эмнэл зүйн шатлал буюу /GLINIG LADER/”-ийг хэрэгжүүлж, 577 буюу нийт сувилагч, тусгай мэргэжилтний 71%-ийг хамруулсан.
28	2.2.31. Хүн амд эрүүл аж төрөх, амьдралын зөв дадал эзэмшүүлэх ажлыг хүүхэд наснаас нь хэвшүүлэх зорилгоор сургуулийн өмнөх болон		Албан бус сургалтад хамрагдсан тоо	2023	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр	Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг боловсролын байгууллагын 56 нэгжид зохион байгуулсан. Сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагад “Зөвийг дадал болгоё” аяныг өрнүүлж, эцсийн үр дүнг эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ шүдийг угаах

	ерөнхий боловсролын хөтөлбөрт тусган эрүүл амьдралын зан үйлийг хэвшүүлнэ.						уралдаанаар дүгнэж үнэлсэн. Уг арга хэмжээ улсын хэмжээнд анх удаа зохион байгуулагдаж, 248 хүүхэд, 248 эцэг эх, асран хамгаалагч, 64 багш оролцсон байна. Ерөнхий боловсролын сургуулиудад 7 хоногт 1 удаа ангидаа шүд угаах аяныг зохион байгуулж, 24 сургуулийн 25,122 суралцагчийг хамруулсан. Мөн Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй 39 цэцэрлэг, 24 сургууль, 1 политехник коллеж, 1 их дээд сургууль, нийт 65 байгууллагын эмч, эрхлэгч, эрүүл мэндийн багш, анги удирдсан багш нарыг хамруулан, шүд угаах онол, дадлага хосолсон 20 удаагийн сургалт зохион байгуулж, 1,628 багш, ажилтан, 1,076 эцэг эх, 4,799 хүүхэд хамрагдсан. ЕБС-иудад шүд угаах орчныг бүрдүүлэх чиглэлээр 2 сургуульд шүд угаах булан байгуулсан, 3 сургуульд бэлтгэл ажлыг хангаж байгаа, 6 сургуульд шүд угаах цагийг тогтмолжуулан хэрэгжүүлж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, “Мишээл хүүхэд сан” ТББ, Эрүүл мэндийн газар, Шүдний холбоо хамтран 2025 оны 10 дугаар сарын 8–10-ны өдрүүдэд сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, 85 сургуулийн болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эмч, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, шүдний эмч, эрүүл ахуйч нарыг хамруулсан. Сургагч багш нарын оролцоотойгоор 22 удаагийн сургалт зохион байгуулж, шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зөв дадал хэвшүүлэх, шүд угаах аргачлал, шүдний цооролтын талаарх мэдлэг олгох үйл ажиллагаанд 426 багш, ажилтан, 1,151 эцэг эх, 4,962 хүүхэд хамрагдсан байна.
29	2.2.32. Хүүхэд чөлөөт цагаараа эрүүл мэнд, бие бялдрын зөв дадал эзэмших орчин, нөхцөлийг орон сууцны	ОНТ 2,972,9	Спорт заалны тоо	2023	34	38	Тайлант хугацаанд хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг эрүүл, идэвхтэй өнгөрүүлэх орчныг сайжруулах, спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ашиглалт, үйл ажиллагааг хэвийн хангах зорилгоор орон нутгийн

	гадна талбай, сургуулийн орчинд бүрдүүлнэ.					<p>төсвийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлж ажилласан.</p> <p>Энэ хүрээнд “Эрдэнэт Arena” спорт цогцолборын зураг, төсөв боловсруулах ажилд орон нутгийн төсвөөс 631.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Хотын төвийн хэсэгт унадаг дугуйн зориулалтын замыг 1.4 км-ээр үргэлжлүүлэн барих ажлыг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсөвт 618.9 сая төгрөг тусгасан.</p> <p>Ерөнхий боловсролын 6, 7, 8, 16 дугаар сургуулийн спорт заалын засвар, шинэчлэлийн ажилд 1 тэрбум 560.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, сургуулийн орчинд биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөлийг сайжруулсан. Мөн Спортын А, Б заал болон Эрдэнэт спорт амралтын хүрээлэнгийн тогтмол үйл ажиллагааны зардалд орон нутгийн төсвөөс 163.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.</p> <p>Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 1 фитнес клуб, 1 спорт заал шинээр байгуулснаар аймгийн хэмжээнд спорт цогцолбор 1, усан бассейн 2, спорт заал 38, фитнес клуб 15, амралт, чөлөөт цагийн 130 талбай ажиллаж, хүүхэд, залуучууд, иргэд чөлөөт цагаараа биеийн тамир, спортоор тогтмол хичээллэх боломж бүрдсэн байна.</p>	
30	2.2.33. Аймаг, сум, дүүрэг, хороо бүрд иргэд эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөдөлгөөн, иог, бүжиг хийх зэрэг цогц үйлчилгээ авах боломж бүхий “Эрүүл зөв		Фитнесс, клубын тоо	2023	40	41	<p>Аймгийн хэмжээнд 15 фитнес клуб, 6 иог, 8 бүжгийн клуб, эрүүл зөв хооллолтын 12 клуб тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Фитнес клубүүдээс 3 клуб нь магадлан итгэмжлэгдэн ажиллаж байсан ч магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан тул дахин итгэмжлэлийг сунгуулахаар Биеийн тамир, спортын улсын хороонд хүсэлтээ хүргүүлээд байна. Тайлант хугацаанд фитнес клуб 1-ээр нэмэгдэж, 7 хоногт давхардсан тоогоор 2600 иргэн хичээллэж байна. Мөн агаарын болон бясалгалын иогт давхардсан</p>

	амьдрал” жижиг төвүүд ажиллуулах боломжийг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор дэмжин хөгжүүлнэ.						тоогоор 600 иргэн үйлчлүүлсэн. Бүжгийн клубуудад давхардсан тоогоор 10700 үйлчлүүлэгч тогтмол хичээллэсэн. Төрийн албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, идэвхтэй хөдөлгөөнд хамруулах ажлын хүрээнд 7 фитнес клубтэй хамтран ажиллаж 392 албан хаагчийг 20-40% хөнгөлөлттэй үнээр хичээллүүлсэн.
31	2.2.34. Эрүүл зөв дадал хэвшил эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах багш, мэргэжилтэн, сургагч багш нарыг бэлтгэж мэдлэг, чадвар болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах, сургах арга зүйг тогтмол сайжруулах боломжийг бүрдүүлнэ.		Эрүүл зөв дадал хэвшил эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах бэлтгэгдсэн багш, мэргэжилтэн, сургагч багш нарын тоо	2023	195		<ul style="list-style-type: none"> <li>- Орхон аймгийн Төрийн байгууллагуудын Эцэг эхийн зөвлөлийн 70 гишүүдэд эрүүл зөв дадал хэвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох сургагч багшаар бэлтгэж чадавхжуулсан.</li> <li>- “Өсвөр үеийнхнийг сонсьёе, ойлгоё” эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Өсвөр үеийн эрүүл мэнд хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох, чадавхжуулах сургалтыг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудын 51 төлөөллийг хамруулан зохион байгуулсан.</li> </ul>
32	2.2.35. Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлийн судалгааг олон улсын түвшинд хэрэглэдэг стандартын дагуу хийж эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөтгөж, судалгаа хийх байгууллагад тавигдах шаардлагыг тодорхой болгож, чадавхжуулна.		Хийгдсэн судалгааны тоо	2023	2	3	Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 494 дүгээр тушаалаар батлагдсан тэмдэглэлт өдрүүдийн нэг болох “Архидан согтуурахаас сэргийлэх 10 хоног”-ийн аяны хүрээнд Эрдэнэт үйлдвэрийн цехүүдийн 581 ажилтан (эрэгтэй 451, эмэгтэй 216) архины хэрэглээний судалгаанд хамрагдаж, судалгааны мэдээллийг SPSS программ ашиглан боловсруулсан. Судалгааны үр дүнгээс харахад 18–25, 26–35 насны ажилтнуудын архины хэрэглээ харьцангуй эрсдэл багатай, харин 36–45, 46–55, 56-аас дээш насны ажилтнуудын дунд аюултай хэрэглээний түвшинд орох магадлал өндөр байна. Эрэгтэй ажилтнуудын архины хэрэглээ аюултай түвшинд илүүтэй ажиглагдсан бол эмэгтэй ажилтнуудынх эрсдэл багатай түвшинд байна. Судалгаанд хамрагдсан ажилтнуудын тал орчим

							<p>хувь нь архины аюултай хэрэглээтэй, 10 ажилтан тутмын 1 нь архины хамааралтай гэж үнэлэгдсэн тул сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 3,485 хүнийг хамруулан ажилласан.</p> <p>Тамхины хамаарлын судалгаанд үйлдвэрийн 582 ажилтан (эрэгтэй 456, эмэгтэй 126) хамрагдсанаас 224 хүн тамхи татдаг, 342 хүн тамхи татдаггүй байна. Тамхины хамааралтай 67 ажилтныг үнэлэхэд маш өндөр хамааралтай 12%, их 21%, дунд 12%, бага 34%, маш бага 21% байна. Судалгааны үр дүнд үндэслэн 268 ажилтанд зөвлөгөө өгч, 380 ажилтныг сургалтад, 150 ажилтныг тамхинаас гарах хөтөлбөрт хамруулж, буруу зуршлаас ангижрахад дэмжлэг үзүүлсэн.</p>
33	2.2.36. Иргэд орчин үеийн эмчилгээ, оношилгооны өндөр өртөгтэй, нарийн төвөгтэй, оношилгоо, эмчилгээ хийлгэх тохиолдолд зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас олгох үйл ажиллагааг өргөжүүлнэ.		ЭМД санхүүжилт	2023	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр УТХ Отгондэлгэр	<p>Иргэдэд өндөр өртөгтэй нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг орон нутгийн бүсийн хэмжээнд үзүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <p>Үндэсний багтай хамтарсан хорт хавдрын нийт 15 хагалгаа хийж</p> <p>Элэгний хорт хавдрын -10</p> <p>Хөхний хортой хавдрын-2</p> <p>Хөхний хоргүй хавдрын -1</p> <p>Нойр булчирхайн хорт хавдрын-1</p> <p>Гэдэсний хорт хавдрын-1</p> <p>Хагалгааг ЭМД -р хийсэн.</p> <p>Мөн өөрийн эмнэлэгийн хүчин чадалд тулгуурлан элэг тайрах мэс заслыг 3 хүнд Эрүүл мэндийн даатгалаар тус тус хийндсэн.</p> <p>Тайлант хугацаанд ангиографи судсан дотуурх оношлогоо эмчилгээ мэс заслын тусламж үйлчилгээг 404 өвчтөн үйлчлүүлэгчдэд Эрүүл мэндийн даатгалаар тусламж үйлчилгээг үзүүлэн орон нутагтаа нутагшуулаад байна.</p> <p>Ингэснээр иргэд даатгуулагчид Эрүүл мэндийн даатгалаараа эдийн засгийн хэмнэлттэйгээр өндөр өртөгт нарийн мэргэжлийн эмнэлэгийн тусламж</p>

							үйлчилгээг авч байна.
34	2.2.37.Иргэн, даатгуулагч эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээ болох сэргээн засах, сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ авах зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжийг бүрдүүлнэ.		Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо	2023	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр	<p>Аймгийн хэмжээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 4 дүгээр бүлгийн 2044, 5 дугаар бүлгийн 183, нийт 2227 иргэн байнгын хяналтад байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, уламжлалт, сэргээн засах, хөнгөвчлөхийн эмч, сувилагч нараас бүрдсэн олон мэргэжлийн баг ажиллуулж, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлж байна.</p> <p>Гэрийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд нийт 523 иргэн хамрагдсан бөгөөд уламжлалт болон сэтгэл зүйн эмчилгээг хавсран үзүүлснээр эмчилгээний үр дүн 0.9 хувиар нэмэгдсэн байна. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Хавдар, хөнгөвчлөхийн тасагт 558 иргэн (хорт хавдартай 458, хоргүй хавдартай 100) хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ авч, 657 иргэн хими эмчилгээнд хамрагдсан.</p> <p>Аймгийн хэмжээнд сэргээн засах тусламж, үйлчилгээг 17 эрүүл мэндийн байгууллага үзүүлж байна. Орон нутгийн санхүүжилтээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <p>“Хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн болон ахмад настнуудыг үзлэг, оношилгоо, сэргээн засах дасгал хөдөлгөөн, эмчилгээнд хамруулах” үйл ажиллагааны хүрээнд 2466 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд давхардсан тоогоор 13,115 удаагийн урт болон богино хугацааны сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>“Солонгон ертөнц” сэргээн засах клиник дэмжлэгт</p>

						<p>төслийг 17.0 сая төгрөгийн санхүүжилттэйгээр хэрэгжүүлж, СӨБ-ын 27 болон 7 дугаар цэцэрлэгийн тархины саа, саажилт, эпилепси оноштой 15 хүүхдэд 3 сарын хугацаанд урт хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлж, нийт 1920 удаагийн үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>“Ахмад настнуудыг үзлэг, оношилгоо, сэргээн засах дасгал хөдөлгөөн, эмчилгээнд хамруулах” үйл ажиллагаанд 25 ахмад настан үений эхо болон сэргээн засах тусламжид хамрагдсан.</p> <p>“Сэргээн засалт ба хөгжлийн бэрхшээл” сэдэвт өдөрлөгийг зохион байгуулж, 15 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЭСЦ-ын сэргээн засах эмчийн үзлэг, хөдөлгөөн засал болон бусад сэргээн засах эмчилгээнд хамруулсан.</p> <p>Аймгийн хэмжээнд сэргээн засах тусламж, үйлчилгээ шаардлагатай 1876 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд давхардсан тоогоор 9295 удаагийн урт болон богино хугацааны сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудад урт болон богино хугацааны сэргээн засах тусламж, үйлчилгээнд 3321 иргэн хамрагдаж, нийт 265.4 сая төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон байна.</p>	
35	2.2.39.Алслагдмал сум, орон нутаг, хот, нийслэлд амьдарч		Цахим системийн	2023	Гүйцэтгэлээр	Гүйцэтгэлээр	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 161 эрүүл мэндийн байгууллага интернэтийн сүлжээнд 100 хувь холбогдсон бөгөөд үүнээс 13

	байгаа хүмүүст үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар ижил түвшинд очиж, цахим эрүүл мэндийн системд бүрэн шилжинэ		хөгжүүлэлт			<p>эрүүл мэндийн байгууллага “Юнивишн”, “Мобинет” ХХК-ийн 20 Mb/s хурдтай dedicated шилэн кабелийн өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбогдсон байна.</p> <p>Тайлант хугацаанд төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд ННЕР албан ёсны программ хангамжийн хүрээнд E-Health, health.gov.mn, karte.mn, hinfo.mn зэрэг цахим системүүдийг өдөр тутмын үзлэг, тусламж үйлчилгээний бүртгэлд тогтмол ашиглаж байна. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд ашиглагдаж буй E-Health цахим системийн хөгжүүлэлтийг тогтмол хийж, эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг тус системд холбон ажиллуулж байна. Мөн дүрс оношилгооны PACS системийг ННЕР системтэй уялдуулснаар мэдээлэл солилцох боломж бүрдсэн.</p> <p>Алслагдсан иргэдэд тусламж, үйлчилгээ ойртуулах зорилгоор Жаргалант сумын эрүүл мэндийн төв болон 5 өрхийн эрүүл мэндийн төвд мобайл технологийг нэвтрүүлж, тайлант хугацаанд гэрийн эргэлтийн IV, V бүлгийн хяналт, алслагдсан багийн малчдын эргэлт, явуулын болон байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэгт ашиглан давхардсан тоогоор 10,000 гаруй иргэнд тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна.</p> <p>Мөн Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ E-Mongolia системээр дамжуулан эрүүл мэндийн чиглэлийн 19 төрлийн үйлчилгээг иргэдэд цахимаар үзүүлж, төрийн үйлчилгээний хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлсэн.</p>
Хэрэгжилтийн дундаж хувь						

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ

**“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРСЭН ТҮВШИН  
(Орхон аймгийн Эрүүл мэндийн газар)**

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2019 он	Хүрэх түвшин, 2025	Хүрсэн түвшин 2025.12	Тайлбар
1	Хүн амын дундаж наслалт	Жил	72.15	76.1	73.66	Орхон аймгийн 2025 оны хүн амын дундаж наслалт 73.66 ба өмнөх оноос 0.32 насаар өссөн.
2	Төрөлтийн нийлбэр коэффициент (нэг эмэгтэйд ногдох)	тоо	2,9	3,3	1.7	2025 оны эхний 11 сарын байдлаар 1761 эх амаржиж, 1774 хүүхэд амьд төрсөн нь нийт 15-49 хүртэлх насны эмэгтэйчүүдэд төрөлтийн нийлбэр коэффициент 1.7 болж 0.1 хувиар буурсан байна.
3	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	Промилл	8.3	8	6.8	Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдлийн 12 тохиолдол бүртгэгдэж 1000 амьд төрөлтөд 6.8 өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6 тохиолдлоор буюу 3.0 промиллоор буурсан.
4	1000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн харьцаа	Просани тимилл	0	0	0	Эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй.
5	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хувь	Хувь	76.3	84,7	78.6	2025 оны эхний 11 сарын байдлаар артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт 18-аас дээш насны 63414 хүн хамруулахаар төлөвлөснөөс 49835 /78.6%/ хүн хамрагдаж өмнөх оны мөн үеэс 15.7 хувиар буурсан.

6	Тухайн жилийн товлोलт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	Хувь	98.9	98.9	99.7	Аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар 11944 хүүхэд товлोलт дархлаажуулалтад хамрагдахаас 11907 хүүхэд хамрагдаж 99.7 хувь, өмнөх оны мөн үеийн түвшинд байна.
7	10000 хүн амд вируст гепатитын өвчлөл	тоо	3,4	2,5	0.4	Вируст гепатит өвчний 4 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 0.4 промилл, өмнөх оны мөн үеийн түвшинд байна.
8	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	хувь	88,9	92	100%	Тайлант хугацаанд эрүүл мэндийн даатгалыг төр хариуцдаг даатгуулагч 72711, албан журмын даатгуулагч 24477 иргэн хамрагдаж, хамрагдалт 100% байна.